

## Үйл ажиллагаа

**Хүрэх үр дүн 1-н хүрээнд:** ЭМХТ-ийн төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалтанд үнэлгээ хийж, асуудлыг тодорхойлох; төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалтыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх; төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалттай холбоотой явцын хяналт, үнэлгээний механизмыг сайжруулан бэхжүүлэх




**Хүрэх үр дүн 2-ийн хүрээнд:** Төгсөлтийн дараах сургалтын систем болон сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж сайжруулах; сургач багш бэлтгэх сургалт (TOT)-ыг зохион байгуулах; сургалтын багц хэрэглэгдэхүүн боловсруулах

Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох (Яаралтай тусlamж, гэмтэй согог судал, халдварт ёвчин судал, яаралтай тусlamжийн холбогдох чиглэлүүд)



**Хүрэх үр дүн 3-ийн хүрээнд:** Хөдөө орон нутагт загвар аймаг сонгон авч, сургалтын тогтолцоог сайжруулах; яаралтай тусlamж, хүүхэд зэрэг сонгосон чиглэлээр багц цагийн сургалт зохион байгуулах; дээд шаталалын эрүүл мэндийн байгууллага нь дараагийн шаталын эрүүл мэндийн байгууллагыг удирдан чиглүүлж ажиллах (Guidance system) шаталсан тогтолцоог бий болгох



Загвар аймаг: Эхний үе шат: Орхон аймаг, Булган аймаг  
Хоёр дахь үе шат: Дорнод аймаг



## Монгол улсын анхан ба хоёр дахь шаталын эмнэлгийн мэргэжилтийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл

(2015 он - 2020 он)



Улсын Нэдүгээр Төв  
Эмнэлэг



Орон нутаг дахь анхан  
шаталалын эмнэлэгт ажиллан  
суралцаж буй эмч



Орон нутаг дахь анхан  
шаталалын эмнэлэг

Улаанбаатар хот, Монгол Улс 2016 он

**ЖАЙКА** Монгол дахь төлөөлөгчийн газар  
Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар  
(Төв шуудан 682, Улаанбаатар 211213, Монгол Улс)  
Тел: +976-11-312393, 311329 Факс: +976-11-310845

**Төслийн оффис**  
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн байр, 3-р давхар 306,  
СБД, 1-р хороо, Энхтайваны гудамж 136,  
Улаанбаатар-210648, Монгол Улс  
Тел: +976-70110894 И-мэйл: jica.pgthp@gmail.com

**Монгол улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн  
мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг  
сайжруулах төсөл  
(2015 он – 2020 он)**

Монгол улс нь төв Азид оршдог, 1.56 сая км<sup>2</sup> газар нутагтай, (Японоос 4 дахин том), 3 сая хүн амтай (хүн амын нягтаршил бага), засаг захиргааны хувьд 21 аймаг, 336 сумтай. Эрт дээр үеэс мал аж ахуй эрхэлж ирсэн. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж зэс, нүүрс, ховор металл зэрэг ашигт малтмалын олдворолт ихэсч байна. 1990 оноос хойш Монгол улс нь социалист нийгмээс ардчилсан нийгэмд шилжих, зах зээлийн эдийн засагтай орон болж 10 гаруй жил эдийн засаг тогтвортгүй байсан ч ойрын үед эдийн засаг эрчимтэй ёсөх хандлагатай байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд нярайн эндэгдэл (1,000 төрөлт тутамд) 1990 онд 77 байсан бол 2013 онд 26 хүртэл буурч, эхийн эндэгдэл (10,000 төрөлт тутамд) 1990 онд 100 байсан бол 2013 онд 68 (ДЭМБ, 2013 он) хүртэл буурсан үзүүлэлтээс харахад улсын хэмжээнд эрүүл мэндийн суурь үзүүлэлтүүд сайжирч байна. Нийслэл Улаанбаатар хот дахь эрүүл мэндийн байгууллагудад эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл тогтол хийгдэж дэвшил гарсаар байгаа хэдий ч нярайн эндэгдэл хотод 24, хөдөө орон нутагт 48, тав хүртэлх наасны хүүхдийн эндэгдэл (1,000 төрөлт тутамд) хотод 28, хөдөө орон нутагт 62 (MICS Summary Report, 2010) байгаа нь хот, хөдөөгийн ялгаа их байгааг харуулж байна. Иймд хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын тусlamж үйлчилгээг сайжруулах нь эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлуудын нэг юм. Мөн 100,000 хүн ам тутамд 263 эмч байгаа нь дэлхийн дундаж тоо болох 170-аас их боловч эдгэрэй боловсон хүчин ихэвчлэн Улаанбаатар хотод төвлөрсөн байна.


Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хүртээмж газар нутаг, хүн амын байршилаас хамааран харилцан адилгүй байгаагаас үүдэн Засгийн газар 2008 оноос хойш хүний их эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх



Эрүүл мэндийн үзүүлэлт

	Монгол Улс 1990 он	Монгол Улс 2011 он	Япон Улс 2011 он	Дэлхийн дундаж 2011 он
Нярайн эндэгдэл (1,000 төрөлт тутамд)	76	16.3	2	35
5 хүртэлх наасны хүүхдийн эндэгдэл (1,000 төрөлт тутамд)	107	20.0	3.4	51
Эхийн эндэгдэл (100.000 төрөлт тутамд)	120	63	3.8	210
Дундаж насалт	60.3 (2013)	69.1 (2013)	84.2 (2013)	71 (2013)
Эмчийн тоо (100.000 хүн тутамд)	263	237	170	

МОНГОЛ УЛСАД МӨРДЖ БҮЙ ЭРҮҮЛ МЕНДИЙН ТОГТОЛЦОО



зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгон, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг зэрэг орон нутгийн анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагад ажиллуулахаар томилох зэргээр хөдөө орон нутаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн дутагдлыг арилгах арга хэмжээ авч ирсэн. Ийм байдлаар эмнэлзүйн ямар нэгэн сургалтанд хамрагдалгүйгээр эмч дутагдалтай орон нутгийн эмнэлгүүдэд хуваарилагдан ажиллаж байгаа нь эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар доголдоход нелөөлж байна.

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт (эмнэлзүйн дадлага бүхий резидентийн сургалт) нь анаагаах ухааны их дээд сургууль төгсөөд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг зэрэг томилогдон ажилласаны дараа 3 дахь жилээс эхлэх бөгөөд, сургалт эрхлэгч байгууллагууд нь зөвхөн Нийслэлийн төв эмнэлгүүд, тусгай мэргэжлийн төвүүдээр хязгаарлагддаг.

Сүүлийн үед хүн амын дундах өвчлөлийн бүтцэд өөрчлөлт орж, чихрийн шижин өвчин, цусны дараалт ихсэх өвчин, өмөн үү, зүрх судасны өвчлөл, зам тээврийн осол гэмтэл, бэртэл зэрэг халдварт бус өвчлөлүүд ихсэх хандлагатай байгаа зэрэг асуудлуудад арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй.

Монгол улсын Засгийн газар 2010 оноос эрүүл мэндийн салбарын хүний нөөцийт сургах бодлого (2010-2014 он)-ын хүрээнд орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагын боловсон хувинг хуваарилан ажиллуулах ажлыг эрчимтэй эхлүүлсэн нь зарим нэг үр дүнгээ өгч байна. 2013 оноос эхлэн Эрүүл мэнд спортын яам (цаашид ЭМСЯ гэх) нь орон нутгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарч, бодлогын чанартай хууль, журамд өөрчлөлт оруулж байна.

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгийн эрүүл мэндийн салбарын боловсон хүчиний чадварыг дээшлүүлэх нэн тэргүүний шаардлага тулгарч байгаатай холбогдуулан хөдөө орон нутгийн тусlamж үйлчилгээг сайжруулах зорилгоор эдгэрэй эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд чиглэсэн төгсөлтийн дараах сургалтыг удирдан зохион байгуулах чадавхийг дээшлүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх талаар Монголын Засгийн газрын зүгээс Японы Засгийн газарт санал тавьсан. Уг саналыг Японы тал хүлээн авч, “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого” болон “Төгсөлтийн дараах сургалтын чанарыг дээшлүүлэх бодлого”-д тулгуурлан хамтын ажиллагааны төсөл боловсруулсан.

Энэхүү төслийн зорилго нь орон нутаг дахь анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулахад оршино. Эмч нарт чиглэсэн яаралтай тусlamж болон бусад холбогдох нарийн мэргэжлийн чиглэлийг сонгон авч төсөл хэрэгжүүлнэ. Төслийн үйл ажиллагааны хүрээнд үндсэн мэргэшлийн сургалтын чанарыг дээшлүүлэх, сургагч багш нарыг чадавхижуулах, сургалтын багц хэрэглэгдэхэүүн (training package) боловсруулах, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын төгсөлтийн дараах сургалт явуулах чадварыг сайжруулах зэрэг ажил тусгагдсан.

Төслийн гол хамтрагч байгууллагаар Монгол улсын хэмжээнд төгсөлтийн дараах сургалтыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилладаг ЭМСЯ, Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид ЭМХТ гэх) байх ба загвар аймгүүд дахь Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Нийслэл дэх сургалт эрхлэгч байгууллагуд мөн адил төсөл хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэйгээр оролцно. Үүнээс гадна Японы Засгийн газрын буцалтгүй тусlamжаар баригдах “АШУУС-н сургалтын эмнэлэг” (2015-2018 он)-тэй төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр хамтарч ажиллана.

### Хэтийн зорилго

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах

### Төслийн зорилго

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах

### Хүрэх үр дүн

- ЭМСЯ болон ЭМХТ-н төгсөлтийн дараах сургалтын удирдлага, зохион байгуулалтын чадавхи сайжирна.
- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсронгуй болно.
- Загвар аймгийн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын систем тогтвортой болно.